

САНХҮҮГИЙН ГҮЙЦЭТГЭЛ 2024 ОНЫ 3-Р УЛИРАЛ

/Аудитлагдаагүй, Монголбанк тайлан суурьтай/

2024 оны 10-р сар



САНХҮҮГИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ /2024 оны 3-р улирал/

2024 онд Монголбанкны Мөнгөний бодлогын хороо гурван удаагийн шийдвэрээр бодлогын хүүг 13%-с 10%-д хүргэж бууруулав. 2023 онд 7.9% байсан инфляцын түвшин энэ оны эхний хагас жилийн эцсээр 5.1%-д хүртэл буурсан бол 9-р сард 6.7%-д хүрч эрчимжсэн ч төв банкны зорилтот интервалд хадгалагдсан хэвээр байна. Мөнгөний нийлүүлэлт 8-р сарын байдлаар 41.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 8.9 их наяд төгрөгөөр буюу 27.3%-р өслөө. Ам.долларын ханш өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй тогтвортой байв. Фитч агентлаг Монгол улсын зээлжих зэрэглэлийг “B+” тогтвортой төлөвт болгон ахиуллаа.

Голомт банк олон улсын зах зээл дээрээс гурван жилийн хугацаатай 300 сая ам.долларын бондыг амжилттай босгож, арав гаруй жил тасраад байсан Монголын арилжааны банкуудын олон улсын зах зээл дэх санхүүжилтийн үйл ажиллагааг дахин сэргээлээ. Мөн Saison Investment Management, Agents for Impact, responsAbility зэрэг ОУ-ын байгууллагуудаас 38.0 сая ам.доллар тогтвортой санхүүжилт, бичил бизнесийг дэмжих зорилготой урт хугацаат санхүүжилтийг татан төвлөрүүлэв.


Банк сегментийн хувьд тэнцвэртэй өсөлтийг үзүүлж нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 63.3%-р тэлэв. Зээлийн өсөлтийн нөлөөгөөр 2024 оны 3-р улирлын эцсээр хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 32.6%-р өсөж 934.7 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр хүүгийн орлого 16.9%-р өсөж 391.3 тэрбум төгрөгт хүрэв. Мөн бизнесийн өсөлт, зах зээл зээлийн орчны нөлөөгөөр банкны цэвэр хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс өндөр өсөлтийг үзүүлэв. Зардлын хяналтыг хэрэгжүүлснээр своп нөлөө хассан зардал орлогын харьцааг 38.0%-д хадгалж чадлаа.

Сан үнэлгээний зардлын өмнөх үйл ажиллагааны цэвэр ашиг 124.3%-р өсөж 426.4 тэрбум төгрөгт хүрэв. Активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн харьцаа (NPL) өмнөх оны мөн үе 6.1%-аас 3.0% хүрч буурсан бол 2024 оны 3-р улирлын эцсээр 24.5 тэрбум төгрөгийн сан буцаасны орлоготой гарч ашигт эерэг нөлөө үзүүллээ.

2024 оны III улирлын эцсээр татварын дараах цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 2.7 дахин өсөж 348.2 тэрбум төгрөгт хүрээд байна. Мөн жилээр илэрхийлсэн дундаж өөрийн хөрөнгийн өгөөж (ROAE) 20.1%-с 43.0%-д хүрч сайжрав.

Банк Монголбанкнаас тавьдаг шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.

ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ /2024 оны 8-р сар/



Арилжааны хэмжээ
28%



Онлайн худалдааны
гүйлгээний тоо, дүн
78%, 54%
Q2'2024 байдлаар



Кастодиан банкны
харилцагчийн тоо, хэмжээ
43%, 55%
Q2'2024 байдлаар



Орон сууцны зээл
24%



Кредит карт
47%



Аккредитивын хэмжээ
65%

Эх сурвалж: Монголбанкны статистик ашиглав




СЕГМЕНТ БҮТЭЦ* БОЛОН ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ**

* Дотоод аргачлал


** Зах зээлд эзлэх хувь 2024 оны 8 сар

БАЙГУУЛЛАГЫН ЗЭЭЛ

Зах зээлд эзлэх %



Голомтын зээлд эзлэх %




Корпорэйт:
₮2.1 их наяд
YTD %: +55%


ЖДБ:
₮1.6 их наяд
YTD %: +42%

БАЙГУУЛЛАГЫН ЭХ ҮҮСВЭР

Зах зээлд эзлэх %




Голомтын депозитод эзлэх %




Байгууллага:
₮4.5 их наяд
YTD %: +2%

РИТЭЙЛ ЗЭЭЛ

Зах зээлд эзлэх %




Голомтын зээлд эзлэх %




Ритейл:
₮3.4 их наяд
YTD %: +46%

РИТЭЙЛ ЭХ ҮҮСВЭР

Зах зээлд эзлэх %



Голомтын депозитод эзлэх %




Ритейл:
₮3.7 их наяд
YTD %: +11%

БАЛАНСЫН ГҮЙЦЭТГЭЛ Q3'2024

Балансын үзүүлэлт (тэрбум ₮)	2023Q3	2023Q4	2024Q3	YTD	%
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,701	3,614	2,645	(969)	-26.8%
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан	1,153	1,203	843	(360)	-29.9%
Хөрөнгө оруулалт	838	1,175	1,047	(128)	-10.9%
Цэвэр зээл	4,095	4,576	6,915	2,339	51.1%
Үндсэн хөрөнгө	510	559	605	46	8.2%
Бусад актив	350	343	416	73	21.3%
Нийт хөрөнгө	9,648	11,469	12,470	1,001	8.7%
Харилцагчдын эх үүсвэр	6,749	7,725	8,151	426	5.5%
Харилцах	3,347	3,979	4,079	100	2.5%
Хадгаламж	3,402	3,745	4,072	326	8.7%
Банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	1,598	2,193	1,692	(501)	-22.8%
Бусад эх үүсвэр	253	380	1,194	814	214.4%
Бусад өр төлбөр	151	225	222	(3)	-1.2%
Нийт өр төлбөр	8,751	10,522	11,258	736	7.0%
Нийт өөрийн хөрөнгө	897	947	1,211	265	27.9%
Чанаргүй зээлийн харьцаа	6.1%	5.0%	3.0%		
Эрсдэлийн хүрэлцээний харьцаа	101.4%	106.2%	104.8%		
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR, Tier 1)	16.4%	15.9%	14.6%		
ТТГЧ-ын харьцаа	39.0%	38.3%	30.8%		

Аудитлагдаагүй, Монголбанк тайлан суурьтай



Балансын гүйцэтгэл:

- Олон улсын зах зээл дээрээс 300 сая ам.долларын бондыг амжилттай босгож балансaa тэлэв.
- Харилцагчдын эх үүсвэр өнгөрсөн оны эцсээс 426 тэрбум төгрөгөөр /5.5%/ өсөж 8.2 их наяд төгрөгт хүрэв.
- Банк сегментийн хувьд тэнцвэртэй өсөлтийг үзүүлж цэвэр зээл 2.3 их наяд төгрөгөөр /51.1%/ өсөж 6.9 их наяд төгрөгт хүрэв.
- Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (CAR) болон 1-р зэргийн өөрийн хөрөнгийн (Tier1) хүрэлцээний харьцаа 14.6%-д хүрэв.
- Банк Монголбанкнаас тавьдаг шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллалаа.


ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ Q3'2024

Орлогын тайлан (тэрбум ₮)	2023Q3	2023Q4	2024Q3	YoY	%
Хүүгийн орлого	704.8	962.0	934.7	230.0	32.6%
Хүүгийн зардал	370.0	507.3	543.4	173.5	46.9%
Цэвэр хүүгийн орлого	334.8	454.7	391.3	56.5	16.9%
Цэвэр хүүгийн бус орлого	(4.3)	(3.1)	224.5	228.8	n/m
Шимтгэл хураамжийн орлого	75.8	103.3	91.2	15.4	20.3%
Цэвэр арилжааны ашиг	(45.2)	(56.4)	179.6	224.8	n/m
Арилжааны ашиг	40.1	59.0	61.8	21.6	53.9%
СВОП-ын нөлөө	(85.3)	(115.4)	117.8	203.2	n/m
Бусад хүүгийн бус орлого	9.4	13.0	14.3	4.9	51.8%
Хүүгийн бус зардал	44.4	63.0	60.6	16.2	36.5%
Үйл ажиллагааны орлого	330.4	451.6	615.8	285.3	86.4%
Үйл ажиллагааны орлого /СВОП-гүй/	415.8	567.0	497.9	82.2	19.8%
Үйл ажиллагааны зардал	140.3	198.3	189.4	49.1	35.0%
Үйл ажиллагааны ашиг	190.1	253.4	426.4	236.3	124.3%
Үйл ажиллагааны ашиг /СВОП-гүй/	275.5	368.8	308.6	33.1	12.0%
Эрсдэлийн сангийн зардал	25.6	22.4	(24.5)	(50.1)	n/m
Татварын өмнөх ашиг	164.5	231.0	450.9	286.4	174.1%
Татварын зардал	34.1	50.2	102.7	68.6	201.3%
Цэвэр ашиг	130.4	180.8	348.2	217.7	166.9%
Цэвэр хүүгийн ахиуц*	6.3%	6.3%	5.9%		
Зардал орлогын харьцаа /СВОП-гүй/	33.7%	35.0%	38.0%		
Дундаж өөрийн хөрөнгийн өгөөж /жилээр/	20.1%	20.5%	43.0%		
Дундаж хөрөнгийн өгөөж /жилээр/	1.9%	1.9%	4.0%		

Аудитлагдаагүй, Монголбанк тайлан суурьтай

* Дотоод аргачлал

Татварын дараах цэвэр ашиг /тэрбум ₮/



Харьцуулалт (өмнөх оны мөн үеэс):

- Q1'2023->Q1'2024 +156%
- Q2'2023->Q2'2024 +249%
- Q3'2023->Q3'2024 +167%

Ашигт ажиллагааны гүйцэтгэл:

- Хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 32.6%-р өсөж 934.7 тэрбум төгрөгт, цэвэр хүүгийн орлого 16.9%-р өсөж 391.3 тэрбум төгрөгт хүрлээ.
- Бизнесийн өсөлт, зах зээлийн орчны нөлөөгөөр цэвэр хүүгийн бус орлого өндөр өсөлтийг үзүүлж 224.5 тэрбум төгрөгт хүрэв.
- Сангийн зардлын өмнөх цэвэр үйл ажиллагааны ашиг 124.3%-р өсөж 426.4 тэрбум төгрөгт хүрсэн үр дүнтэй байна.
- 2024 оны 3-р улирлын эцсээр 24.5 тэрбум төгрөгийн сан буцаасны орлоготой гарч ашигт эерэг нөлөө үзүүллээ.
- Татварын дараах цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс 2.7 дахин өсөж 348.2 төгрөгт хүрэв.
- Жилээр илэрхийлснээр ROE 43.0% ROA 4.0%-д тус тус хүрч сайжирсан үр дүнтэй байна.

АНХААРУУЛГА

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагууд нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ыг мөрддөг бол Арилжааны банк нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн багц материал”-ыг дагаж мөрддөг. Энэхүү журамд 2017 оноос хойш шинэчлэгдсэн зарим стандарт (СТОУС-9, СТОУС-15, СТОУС-16 гэх мэт)-ын өөрчлөлтийг тусгаагүй байдаг. Иймд дээрх журмын дагуу бэлтгэн улирал бүр олон нийтэд мэдээлж буй тайлан нь Банкны СТОУС-т нийцсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй байж болох ба зээл, эх үүсвэрийн сегментийн бүтцийг банкны дотоод аргачлалд тулгуурласан болно.

Анхаарал тавьсанд баярлалаа